

## Олон улсын төслийн багийн анхдугаар онлайн хурал

2021 оны 03 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

### Эхлэх уулзалтын талаарх мэдээллийг багийн гишүүдэд танилцуулсан тухай

**Хурал хийсэн газар:** Хурлыг google meet ашиглан <https://meet.google.com/iwi-jxxs-dhq> линкээр хийлээ. Хурлыг 10:00 цагт эхэлж, 12:00 цагт дуусгав.

**Хэлэлцэх асуудал:** ОУ-ын хамтрагч орнуудын гишүүдтэй хийсэн эхний хуралд **хэлэлцэгдсэн асуудлыг** төслийн багийн гишүүдтэй хэлэлцэх, Олон улсын төслийн багийн бүрэлдэхүүн болон Төслийн үндэсний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах, ажлын багцуудад багтсан ажлыг хуваарилах

#### Хуралд оролцсон:

ЭКО АЗИ БОМДС-ийн Ерөнхий захирал Ц.Адъяасүрэн, ерөнхий менежер А.Эрдэнэбаяр, эрдмийн зөвлөлийн гишүүн Д.Энэбиш, ахлах багш Э.Доржпагма, экологийн тэнхмийн судлаач багш А.Төмөр-Өлзий, экологийн тэнхмийн Англи хэлний багш А.Гүнжээ нар оролцов.

**Хэлэлцсэн нь:** ОУ-ын хамтрагч орнуудын гишүүдтэй хийсэн эхний хуралд хэлэлцэгдсэн зүйлсийг төслийн багийн гишүүдтэй Ажлын багц бүрээр хэлэлцэв.

#### Ц.Адъяасүрэн

#### Ажлын багц 1.1

Олон улсын төслийн багийн бүрэлдэхүүнийг дараах бүтэцтэй оролцуулна.

1. Ц.Адъяасүрэн., Ерөнхий захирал - Төслийн удирдагч
2. А.Эрдэнэбаяр., Ерөнхий менежер –Төслийн менежер
3. Э.Доржпагма., Ахлах багш – Төслийн олон **баг дахь** улсын зохицуулагч
4. Д.Энэбиш., Эрдмийн зөвлөлийн гишүүн - Сургалтын хөтөлбөр боловсруулах бүлгийн дарга
5. А.Төмөр-Өлзий., Экологийн тэнхмийн судлаач багш - Төслийн техникийн ажилтан
6. Г.Сэлэнгэ., Нягтлан – Төслийн санхүүгийн менежер
7. А.Гүнжээ., Экологийн тэнхмийн Англи хэлний багш - Төслийн орчуулагч
8. Н.Хэрлэнзаяа., Экологийн тэнхмийн туслах багш - Төслийн орчуулагч

Төслийн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллах Монгол улсын үндэсний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах бүтэцтэй байна.

1. Ц.Адъяасүрэн., Ерөнхий захирал - Төслийн удирдагч
2. А.Эрдэнэбаяр., Ерөнхий менежер –Төслийн менежер
3. Э.Доржпагма., Ахлах багш – Төслийн олон улсын зохицуулагч

4. Д.Энэбиш., Эрдмийн зөвлөлийн гишүүн - Сургалтын хөтөлбөр боловсруулах бүлгийн дарга
5. А.Төмөр-Өлзий., Экологийн тэнхмийн судлаач багш - Төслийн техникийн ажилтан
6. А.Гүнжээ., Экологийн тэнхмийн Англи хэлний багш - Төслийн орчуулагч
7. Г.Сэлэнгэ., Нягтлан – Төслийн санхүүгийн менежер
8. Б.Ичинхорлоо., Улаантайгын ДЦГ-ын Хамгаалалтын захиргааны мэргэжилтэн - Төслийн хамтрагч
9. Д.Бямбаа., Аргун манлайлагч ТББ-ын менежер - Төслийн хамтрагч

## **Ажлын багц 1.2**

ТХГН-ийн нөхцөл байдал, ТХГН-ийн ажлын ур чадварын талаархи нөхцөл байдлын шинжилгээ хийхэд **тусгай асуулга** бэлдэнэ. А.Эрдэнэбаяр

## **Ажлын багц 2**

Магистрын сургалтын хөтөлбөр боловсруулах – ТХГНМ чиглэлээр магистрын сургалтын хөтөлбөрийг Орон нутгийн ажлын хэсэг ярилцаж боловсруулна. Энэ чиглэлээр суралцах магистрантуудыг Горхи тэрэлж болон Хөгнө – Тарнын ТХГН-т болон Буриадын ТХГН-т айлчилж дадлага хийлгэнэ.

Англи хэл дээр ном сурах бичиг, сэтгүүл захиалахаас гадна өөрсдийн “ТХГНМ гэж юу вэ” гэх мэтчилэн сурах бичиг гаргана.

## **Ажлын багц 3.1**

Англи хэлгүй ажилтнуудыг хамруулна.

## **Ажлын багц 3.2**

Төслийн техникийн ажилтан А.Төмөр-Өлзийд тоног төхөөрөмж худалдан авах ажлыг хариуцуулав.

Англи хэл дээр ТХГНМ-ийн чиглэлээр ном, сэтгүүл захиалах ажлыг Э.Доржпагмад хариуцуулав.

## **Ажлын багц 3.3**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч орнуудад ажиллагсдын сургалт, танилцах аялалд тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарч ажилтануудаас хамруулна.

## **Ажлын багц 3.4**

Багш бэлтгэх сургалтанд явж ирсэн багш нар сурсан мэдсэнээ дотоодын их дээд сургуулийн багш нарыг сургах, болон дотооддоо магистр бэлтгэнэ.

## **Ажлын багц 3.5**

ТХГНМ—ийн чиглэлээр суралцаж байгаа магистрантуудыг Буриад-ын ТХГН-т дадлагын ажил хийлгэнэ.

#### **Ажлын багц 4.1**

Нөөцийн төвүүд болон олон улсын сүлжээ байгуулж журам гаргах.  
А.Эрдэнэбаяр оролцох  
Дөрвөн Дээд Боловсролын Байгууллагын дэргэдэх нөөцийн төвүүдийн эрхзүйн орчныг боловсруулахад Мижиддорж болон Батжаргал нар хамтран ажиллана.

#### **Ажлын багц 4.4**

“21-р зууны тусгай хамгаалалттай газар нутаг; Сорилтууд ба шийдлүүд “ Бага хурлаар /Ажлын багц 1,2,3/ -ийн үр дүнгийн талаархи хэлэлцүүлгийг Ц.Адъяасүрэн болон Д.Энэбиш нар удирдан явуулна.  
‘Шинэлэг заах болон сурах арга зүйн талаарх бага хурал.” Суралцах айлчлалын үр дүнгийн талаархи хэлэлцүүлгийг А.Эрдэнэбаяр болон Э.Доржпагма нар удирдан явуулна.

#### **Ажлын багц 5.1**

Чанарын баталгаажуулалтын менежмент болон хяналтын хэрэгсэл - чанарын хяналтын багаж хэрэгслүүдийг тогтоох ажлыг А.Эрдэнэбаярт хариуцуулав.

#### **Ажлын багц 5.2**

Сургалтын төлөвлөгөө, модуль материалын чанарын хяналт – ОУ-ын нөхцөлд хүрч байгаа эсэхээ ОУ-ын хөтөлбөр татан авч ажиллах

#### **Ажлын багц 5.3**

Төсөлд хөндлөнгийн хяналт шалгалт хийхдээ Европын стандарт, чанарын баталгаажуулалтын удирдамжийг харгалзан үзэх учраас энэ удирдамжийг нэт-ээс татан авах ажлыг Э.Доржпагмад хариуцуулав.

#### **Ажлын багц 6.1**

Судалгааны мэдээлэл болон төслийн үр дүнг түгээх – Боловсрол шинжлэх ухааны яамаар батлуулсан хөтөлбөрөөр бүх ТХГН-ын ажилтнуудад сургалт явуулж мэдлэг мэдээллийг түгээн ажиллана.

#### **Ажлын багц 6.2**

ТХГН-ын модуль хийх, вэб хуудсаа сайжруулан ажиллагаанд оруулж төслийн мэдээллийг байршуулах болон мэдээлэл авах

#### **Ажлын багц 7.2**

Зохицуулах уулзалт – Урьдчилсан уулзалт хийх. Ингэхэд орон нутагт хэрэгцээтэй байгаа асуудлыг Ичинхорлоогоос авна. Мөн ХААИС болон ЭКО АЗИ БОМДС хоорондоо зохицуулах уулзалтыг хийж болно.

### **Ажлын багц 7.3**

Өдөр тутмын менежмент – Дотооддоо журам гаргана.

#### **Шийдвэрлэсэн нь:**

1. Олон улсын төслийн багийн бүрэлдэхүүн болон Төслийн үндэсний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлаж **Захирлын** тушаал гаргана
2. Ажлын багцуудад багтсан ажлыг багийн гишүүдэд хувиарлав.
3. ОУ-ын эхний хуралд **яригдсан** зарим нэр томъёог тодруулах Үүнд:
  - Жилийн хяналтын төлөвлөгөө /слайд 14 дээр гарсан/ - яаж хийх ямар утгаар оруулсан эсэх
  - Дээд Боловсролын Байгууллагууд Р6-Р9 боловсруулана /слайд 49 дээр гарсан Ажлын багц 6.3-т тусгасан/ – Р6-Р9 гэдэг нь ямар утгатай эсвэл ямар үгийн товчлол болох эсэх
  - Жилийн ажлын төлөвлөгөөний хүснэгт /слайд 56, 58/-д бичигдсэн  $x$ ,  $x=$ ,  $2x$ ,  $2x2=$ ,  $3x$ ,  $4x$ ,  $4x=$  гэсэн тэмдэглэгээнүүдийн тайлбарыг тодруулах

**ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:**

**Э.ДОРЖПАГМА**

**ХЯНАСАН :**

**Ц.АДЪЯАСҮРЭН**